



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/301

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийн үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Ч.Одгэрэл	Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны дарга
Нарийн бичгийн дарга:	С.Наранбаатар	Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн
Гишүүд:	Х.Баттулга	Холбоо, навигацийн, ажиглалтын албаны ерөнхий инженер
	С.Мягмардорж	Монголын нислэгийн удирдагчдын холбооны гишүүн
	С.Энхбаатар	"Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Ч.Одгэрэл/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /С.Наранбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН